

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД М.ЭНХБОЛДЫН БНХАУ-Д ХИЙСЭН АЛБАН ЁСНЫ АЙЛЧЛАЛ

Д.ШҮРХҮҮ \*

Монгол Улсын Ерөнхий сайд М.Энхболд БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Вэнь Зябаогийн урилгаар 2006 оны 11-р сарын 22-27-нд БНХАУ-д албан ёсны айлчлал хийв. Хоёр орны хооронд уламжлал болсон дээд, өндөр хэмжээний яриа хэлэлцээний үргэлжлэл болсон энэ удаагийн айлчлалын Монгол Улсын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд УИХ-ын гишүүн, Сангийн сайд Н.Баяртсайхан, УИХ-ын гишүүн, Зам тээвэр, аялал жуулчлалын сайд Ц.Цэнгэл, УИХ-ын гишүүн, Мэргэжлийн хяналтын сайд У.Хүрэлсүх, УИХ-ын гишүүн М. Зоригт, Д.Дэмбэрэл, Л.Гансүх, Гадаад хэргийн дэд сайд Ц.Цолмон, Үйлдвэр, худалдааны дэд сайд Я.Содбаатар нар оржээ.

Монгол Улсын Ерөнхий сайд М.Энхболд БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Вэнь Зябаотай 2006 оны 11-р сарын 22-нд албан ёсны хэлэлцээ хийлээ. Хэлэлцээний эхэнд Хятадын засгийн газрын тэргүүн Вэнь Зябао хэлэхдээ, “Ноён Ерөнхий сайд М.Энхболд таны манай улсад хийж буй айлчлал нь хоёр орны харилцаа, хамтын ажиллагаанд чухал түлхэц болохын зэрэгцээ эдийн засаг, худалдааны салбарт шинэ хуудас нээнэ гэдэгт итгэж байна. 4700 орчим км нутгаар хиллэдэг манай хоёр улсын хувьд харилцаагаа улам өргөжүүлж байгаад таатай байна” гэлээ. Мөн Хятад-Монголын харилцаа тогтвортой хөгжлийн шинэ үе шатанд байна гэдгийг тэрбээр онцлон тэмдэглэв.

Монгол Улсын Ерөнхий сайд М.Энхболд хариу үг хэлэхдээ, хоёр орон улс төр, эдийн засаг, худалдаа, боловсрол, эрүүл мэнд зэрэг олон салбарт иж бүрэн хамтын ажиллагаа хөгжүүлж байгаа бөгөөд Хятад улстай урт хугацаанд тогтвортой харилцаа хөгжүүлэх бодлогыг Монголын засгийн газар туйлбартай баримталдгийг онцлон тэмдэглэсэн байна.

Хятадын төв хэвлэл “Ардын өдрийн сонин” сонинд Вэнь Зябао, М.Энхболд нарын хийсэн яриа хэлэлцээний үр дүнгийн талаар мэдээлэхдээ, Хятад, Монгол хоёр орон улс төр, эдийн засаг, хүмүүнлэг, соёлын салбарт 5 зүйлт тохиролцоонд хүрсэн нь хоёр талын харилцааг хөгжүүлэх талаар ихээхэн хүч чармайлт гаргаж буйн илрэл хэмээн дүгнэжээ. Тус сонинд мэдээлснээр тэрхүү 5 зүйлт тохиролцоонд :

- Харилцан айлчлалын давтамжийг хадгалахын зэрэгцээ харилцан ойлголцол, итгэлцлийг бэхжүүлэн, хоёр талын түншлэлийн харилцааг бэхжүүлэн хөгжүүлэх;

- Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хамгийн чухал салбар болж буй дэд бүтэц, эрчим хүчний салбаруудад эхэлсэн хамтын ажиллагааг цаашид Монгол улсад цахилгаан станц, авто зам, төмөр зам барих талаар хамтран ажиллах замаар үргэлжлүүлэн хөгжүүлэх, мөн түүнчлэн эдийн засаг, худалдааны харилцааны дунд, урт хугацааны төлөвлөгөөг боловсруулах;

- Байгаль орчныг хамгаалах, байгалийн гамшиг, халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар хамтран ажиллах;

- Соёл, хүмүүнлэгийн солилцоог идэвхижүүлэх, харилцан сургах оюутны тоог аажмаар нэмэгдүүлэх, тохиромжтой үед “үндэстний өдрүүд” зохион байгуулах;

- “Шанхайн хамтын ажиллагааны байгууллага”-ын хүрээнд мэдээлэл солилцох, зохицуулалт хийх явдлыг нэмэгдүүлэх, Хятад, Монгол, Орос 3 улсын хооронд зөвлөлдөх механизмыг сайжруулах, бүс нутгийн тогтвортой байдлыг хамгаалах, хамтын ажиллагааг хөгжүүлэн дэмжих, хар тамхины наймаатай хамтран тэмцэх зэрэг асуудлууд орсон байна.<sup>1</sup>

\* Д.Шүрхүү. ШУА-ийн ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

<sup>1</sup> China, Mongolia reach five-point consensus to further ties, November 23, 2006,

<http://english.peopledaily.com.cn>,

Монголын талын мэдээлснээр засгийн газар хоорондын хэлэлцээний үеэр эрчим хүчний хамтарсан төсөл хэрэгжүүлэх чиглэлээр хийж байгаа хамтын ажиллагааны эхлэлийг дэмжих, дэд бүтцийн салбарт хамтран ажиллах, худалдаанд учирдаг тарифын ба тарифын бус саад тотгорыг багасгах, батлан хамгаалах, соёл боловсрол, бусад салбарын харилцаа, орон нутгийн хамтын ажиллагаа зэрэг олон чиглэлээр хоёр тал байр сууриа илэрхийлцгээжээ. Хятадын томоохон компаниуд Монголын нүүрс, зэсийн орд газруудыг хамтран ашиглахад дэмжлэг үзүүлэхийг Хятадын тал хүссэн байна.

Мөн БНХАУ-ын төр засаг Монгол улстай харилцах харилцаагаа чухалчлан үздэгээ давтан нотлоод Тайвань, Далай ламын асуудлаар Монгол Улсын засгийн газрыг зарчмын байр сууриа цаашид ч үргэлжлүүлэн баримталж Хятадын талд тууштай дэмжлэг үзүүлэхийг хүссэн байна.<sup>2</sup> Гадаад хэргийн дэд сайд Ц.Цолмон айлчлалын дүнгийн талаар зохион байгуулсан хэвлэлийн бага хурал дээр мэдэгдэхдээ, Тайвань бол БНХАУ-ын салшгүй хэсэг гэж үздэг, Далай ламтай зөвхөн шашны шугамаар харилцаатай байж, улс төрийн хэрэгт оролцуулдаггүй зэрэг манай талын байр суурийг Хятадын тал сайшаасан тухай өгүүлж байв.<sup>3</sup>

Хоёр тал худалдаа, хамтын ажиллагааг үр ашигтай, эрүүл саруулаар хөгжүүлэх талаар нэлээд нухацтай хэлэлцсэн байна. Үүний тулд Засгийн газар хоорондын комисс зэрэг одоо байгаа хамтын ажиллагааны механизмыг бүрэн дүүрэн ашиглах, хоёр талын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн гүнзгийрүүлэх тухай Ерөнхий хэлэлцээр байгуулах саналыг монголын тал дэвшүүлж, хоёр талаас ажлын хэсэг томилж ажиллуулахаар болжээ. Худалдаа, эдийн засгийн харилцаанд гарч буй асуудлуудыг тухай бүр нь шийдвэрлэж байхыг санал болгохын хамт Монголд хөрөнгө оруулж буй Хятадын компаниудын эрх ашгийг хамгаалахыг Хятадын тал хүсэв. Мөн Монголд хөрөнгө оруулж буй өөрийн компаниуддаа Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг чанд мөрдөж ажиллахыг

шаардахаа илэрхийлэв.<sup>4</sup>

Засгийн газар хоорондын хэлэлцээ амжилттай болж дууссаны дараа хоёр тал нийтдээ найман баримт бичигт гарын үсэг зурлаа. Үүнд:

-БНХАУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт 50 сая юанийн буцалтгүй тусламж өгөх тухай “Эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”;

-БНХАУ-ын талаас олгохоор амалсан 300 сая ам. долларын хөнгөлөлттэй зээлийг Эгийн голын УЦС-ыг барьж байгуулахад ашиглах тухай Монгол Улсын Сангийн яам, БНХАУ-ын Экспорт, импортын банкны хоорондын санамж бичиг;

-БНХАУ-аас Монгол Улсад 2000 тонн улаан буудай нийлүүлэх тухай солилцох захидал;

-БНХАУ-ын буцалтгүй тусламжаар Монгол Улсад хээрийн экосистемийн судалгааны станц байгуулах асуудлаар судалгааны хэсэг байгуулах тухай солилцох захидал;

- БНХАУ-ын буцалтгүй тусламжаар биеийн тамир, спортын цогцолбор байгуулах тухай солилцох захидал;

- БНХАУ-ын буцалтгүй тусламжаар Монгол Улсад чанарын хяналтын нэгдсэн лаборатори байгуулах асуудлаар судалгааны хэсэг ажиллуулах тухай солилцох захидал;

- Гадаад хэргийн яамд хоорондын 2007-2008 оны хамтын ажиллагааны төлөвлөгөө;

-Монгол Улсын Ашигт малтмал, газрын тосны Хэрэг эрхлэх газар, БНХАУ-ын Геологийн судалгааны газар хооронд Монгол, Хятадын хилийн бүсийн дагуух 1:1 000 000 масштабын геологийн зураг хийх болон дагалдах судалгааны ажил хийх төслийн тухай хамтын ажиллагааны хэлэлцээр зэрэг болно.

Дээрх олон бичиг баримтын дотроос дотоод гадаадынхны анхаарал сонирхлыг татсан чухал асуудлын нэг бол урт хугацааны 300 сая ам.долларын арилжааны хөнгөлөлттэй зээлийг хэрхэн ашиглах тухай асуудал байлаа. БНХАУ-ын дарга Ху Жиньтао 2003 оны 6-р сард анх удаа Монгол улсад айлчлах

<sup>2</sup> “ГАДААД ХАРИЛЦАА” Монгол Улсын ГХЯ-ны мэдээллийн товхимол, 2006 оны №11(176), х-4

<sup>3</sup> “Ардын эрх” сонин 2006 №232 /510/

<sup>4</sup> “Ардын эрх” сонин 2006 №232 /510/

үедээ санал болгосон 300 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн зарцуулалтын асуудлыг хоёр тал эцэслэн шийдвэрлэж, түүнийг Эгийн голд УЦС барихад ашиглахаар тохиролцов. Энэ зээлийг авах асуудлыг Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр 2005 оны 11-р сард БНХАУ-д хийсэн төрийн айлчлалын үеэр баталгаажуулсан билээ. Монгол Улсын Сангийн яам, БНХАУ-ын Экспорт, импортын банкны хооронд байгуулсан санамж бичигт урьд тохиролцсон ёсоор 60 сая ам.долларт манай засгийн газраас баталгаа гаргах бөгөөд 20 жилийн хугацаатай, жилийн 1.75 хувийн хүүтэй авахаар болов. Үлдсэн 240 саяыг уг төсөлд оролцох компаниуд өөрсдөө хариуцах ба зээл мөн л 20 жилийн хугацаатай жилийн 2 хувийн хүүтэй байх ажээ.<sup>5</sup>

Булган аймгийн нутаг дахь Эгийн гол дээр барих энэхүү УЦС нь 220 мВт-ын суурилагдсан хүчин чадалтай. Жилдээ 500 сая кВт. цаг цахилгаан үйлдвэрлэх ба усан сангийн нийт талбай нь 125 км<sup>2</sup> ажээ. Тус станц хөрөнгө оруулалтаа 15-20 жилд нөхөх төдийгүй 100 орчим жил ажиллах бүрэн боломжтой гэсэн тооцоо гарчээ. Ер нь Эгийн голын УЦС барих асуудал бүр 15 жилийн өмнөөс эхэлж, техник, эдийн засгийн үндэслэлийн судалгааг Азийн хөгжлийн банкнаас олгосон 1.4 сая ам.долларын буцалтгүй тусламж, төслийн нарийвчилсан судалгаа, тендерийн бичиг баримтыг 40 жилийн хугацаатай 3.8 сая ам.долларын зээлээр тус тус гүйцэтгэжээ. Швейцарь-Италийн хамтарсан зөвлөх инженерийн баг 1992-1994 онд дээрх станцын техник эдийн засгийн үндэслэл, нарийвчилсан зураг төслийн судалгаа, тендерийн бичиг баримтыг боловсруулжээ. Судалгаагаар тус станцыг барих нь техникийн хувьд боломжтой, эдийн засгийн үр ашигтай, байгаль орчинд сөрөг нөлөөгүй гэсэн дүгнэлт хийсэн байдаг. Эгийн голын УЦС барьснаар төвийн эрчим хүчний системийн тогтвортой ажиллагааг дээшлүүлэн, өөрийн өртгийг бууруулах, цахилгааны нөөцтэй болохын зэрэгцээ импортын эрчим хүчний хараат байдлаас гарч, эрчим хүчний аюулгүй ажиллагаа баталгаатай

болох ач холбогдолтой гэж мэргэжилтнүүд үзэж байна. Мөн төвийн эрчим хүчний систем дэх ачааллын горимыг тохируулах боломжтой болохоос гадна уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийн цахилгааны хэрэгцээг хангаж, улмаар Оюу толгой орчмын эрчим хүчний хэрэгцээг хангах асуудлыг хамтад нь шийдвэрлэх нөхцөл бүрдэх ажээ.<sup>6</sup>

Монгол Улс 2007 оны 1 дүгээр сарын 1-нээс БНХАУ-д төлж эхлэх ёстой 28.3 сая шилжих рублийн болон 5.6 сая швейцарь франкийн өрийг зүй зохистой шийдвэрлэх буюу хвчингвй болгохыг Ерөнхий сайд М.Энхболд хвсч, БНХАУ-ын Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд Вэнь Зябао уг асуудлыг нухацтай судлахаа илэрхийлжээ.<sup>7</sup>

Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын хорооны дарга У Бангуо, Бүх Хятадын Ардын Улс төрийн Зөвлөлдөх Зөвлөлийн дарга Зя Цинлин нар Монгол Улсын Ерөнхий сайд М.Энхболдыг Бүх Хятадын Ардын Их Хурлын ордонд хүлээн авч уулзан, хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны талаар найрсгаар ярилцав.

Ерөнхий сайд М.Энхболдыг хүлээн авч уулзах үедээ БНХАУ-ын төр, засгийн удирдагчид манай улсын тусгаар тогтнол, бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монголын ард түмний сонгосон хөгжлийн замыг хүндэтгэн үзэхээ дахин нотолсон нь энэхүү айлчлалын бас нэг чухал ач холбогдол юм.

Эдгээр уулзалтын дараа Ерөнхий сайд М.Энхболдод Бээжин хотын дарга Ван Чишань бараалхлаа. Ерөнхий сайд М.Энхболд Улаанбаатар, Бээжин хотуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх үйлсэд оруулж байгаа хувь нэмрийг үнэлэн Бээжин хотын даргад талархал илэрхийлээд, Азид төдийгүй дэлхийд хөгжлөөрөө дээгүүрт ордог Бээжин хотоос суралцах зүйл их бий хэмээн тэрээр хэлэв. Бээжин хот 2008 оны Олимпийн зочдыг хүлээж авахад бэлтгэн бүтээн байгуулалтын ажил амжилттай өрнөж байгаа тухай Бээжин хотын дарга Ван Чишань Ерөнхий сайд М.Энхболдод танилцууллаа.<sup>8</sup>

<sup>5</sup> “Өнөөдөр” сонин, 2006.11.24

<sup>6</sup> Мөн тэнд

<sup>7</sup> “Ардын эрх” сонин, 2006 он, №232 /510/

<sup>8</sup> “Өнөөдөр” сонин, 2006.11.25

Айлчлалын бас нэг чухал үр дүн бол БНХАУ-ын засгийн газраас Монгол Улсад нэлээд хэдэн чиглэлээр санхүү, эдийн засгийн тусламж үзүүлэхээр тохиролцсон явдал юм. БНХАУ-ын Засгийн газраас буцалтгүй тусламжийн хэлбэрээр Монгол Улсад 50 сая юань, 2000 тонн улаан буудай, Монгол Улсад хээрийн экосистемийн судалгааны станц, Улаанбаатар хотод биеийн тамир, спортын цогцолбор барих, чанарын хяналтын нэгдсэн лаборатори байгуулж өгөхөөр болсон нь урьд өмнөх өндөр дээд хэмжээний айлчлалын үеэр өмнөд хөршөөс үзүүлж байсан буцалтгүй тусламжаас тоо хэмжээ, цар хүрээгээрээ хол давж байна. Сангийн сайд Н.Баяртсайхан энэ удаагийн айлчлалын үр дүнг тодорхойлон хэлэхдээ, хоёр орны эдийн засаг, хvmvvnлэг, соёлын харилцааг хөгжvvлэхэд их нэмэр оруулсан, шинэ ve шатанд гаргасан айлчлал боллоо. БНХАУ-аас манай улсад үзүүлдэг зээл тусламжийн хэмжээ ч ихээхэн нэмэгдлээ. Урьд нь БНХАУ-аас манай улсад 30 орчим сая юанийн буцалтгүй тусламж олгодог байсан. Энэ удаа хэмжээ нь нэмэгдэж 50 сая юань өгөх болсон тухай мэдэгдсэн билээ.<sup>9</sup>

Сүүлийн жилүүдэд Монгол-Хятадын худалдаа, эдийн засгийн харилцаа тасралтгүй өргөжин тэлж, цар хүрээ далайц нь цаашид ч нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал, 2006 оны эхний 9 сарын байдлаар Хятад-Монголын худалдаа урд жилийн мөн үеийнхээс 88.8 хувиар өсч, 1 тэрбум 130 сая ам. долларт хүрсэн тухай мэдээг Хятадын Синьхуа агентлаг айлчлалын үеэр цацаж байв. Харин 2005 онд Хятад-Монголын худалдааны хэмжээ 860 сая ам.доллар, жилийн өсөлт 24% байв.<sup>10</sup>

Айлчлалын өмнөхөн англи хэл дээр хэвлэгддэг Хятадын өдөр тутмын төв хэвлэл China Daily сонинд Монгол Улсаас БНХАУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Г. Батсүх өгсөн ярилцлагандаа Монгол-Хятадын худалдаа, эдийн засгийн харилцааны тухай нэлээд дэлгэрэнгүй мэдээлэл оруулсан байв. Хятад улс Монголын нийт экспортын 72 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд 2006 оны 9 сарын худалдааны дүн хоёр орны худалдааны хэмжээ анх удаа 1 тэрбум

ам.долларын заагийг давсаныг харуулж байна. Өмнөх жилийн мөн үетэй харьцуулбал Хятад руу гаргасан экспорт 226.3 хувь, оруулж ирсэн импорт 136 хувь тус тус өссөн байна. Хятад улс Монголд 682.8 сая ам.долларын хөрөнгө оруулаад байгаа нь нийт гадаад хөрөнгө оруулалтын 47.4 хувийг эзэлж байна. Элчин сайд Г.Батсүх цааш нь ярихдаа, Монгол Улсын Ерөнхий сайд М.Энхболдын энэ удаагийн албан ёсны айлчлал Монгол-Хятадын хоорондын худалдаа, эдийн засгийн харилцааг улам урагшлуулна гэдэгт би итгэлтэй байна. Алт, зэс, уран, нүүрс, молибден, фосфор, газрын тос зэрэг Монголын эрдэс баялгийн эрэлт хэрэгцээ Хятадад өндөр байна. Монгол Улс ч мөн эдгээр салбарт ихээхэн хөрөнгө оруулах, дэд бүтэц, боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх шаардлагатай байгаа бөгөөд Хятад улс ч энэ чиглэлээр жинтэй хувь нэмэр оруулах бүрэн боломжтой орон гэдгийг тэрбээр ярилцлагандаа онцлон дурджээ.<sup>11</sup>

Монгол Улсын Ерөнхий сайд М. Энхболд 2006 оны 11-р сарын 23-нд Бээжин хотноо “Presidential plaza” зочид буудалд Хятадын олон улсын худалдааг дэмжих зөвлөл (China Council for the Promotion of International Trade (CCPIT) болон Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхим (МХАУТ) хамтран зохион байгуулсан Монгол, Хятадын бизнес эрхлэгчдийн чуулга уулзалтын нээлтэд оролцож үг хэллээ. Тэрбээр хоёр орны бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагаа улам өргөжин тэлж байгааг тэмдэглээд, Монгол Хятадын сайн хөршийн түншлэлийн харилцааг өргөжүүлэн, бодит үйл хэрэг болгоход бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаа чухлыг онцлов. Хятад орон 1999 оноос хойш Монгол улсын худалдааны хамгийн том түнш орон, сүүлийн 8 жилийн турш Монголын хамгийн том хөрөнгө оруулагч орны байр суурийг хадгалсаар байна. Монгол Улсын Засгийн газар гадаадын хөрөнгө оруулалтыг бүхий л хүрээнд дэмжиж, эрх зүйн таатай орчноор хангах бодлого баримталж буйг хэллээ. Тэрбээр айлчлалын үеэр бид Хятадын албаны хүмүүстэй Хятад-Монголын зам тээврийн нэвтрүүлэх чадварыг сайжруулах, Монголоос

<sup>9</sup> “Монголын мэдээ” сонин, 2006 он, №233 /2009/

<sup>10</sup> Neighbours seal US\$100m in deals. China Daily, November 24, 2006

<sup>11</sup> Official visit takes bilateral relationship to new level. China Daily, 2006-11-23

Хятад руу хийх экспортод оногдуулах татвар, тарифын бус саад тотгорыг бууруулах талаар ярилцах болно хэмээн мэдэгдэв. Монголын 50 орчим компанийг төлөөлсөн 200 орчим бизнесийн төлөөлөгчид Ерөнхий сайд М.Энхболдыг дагалдан Хятадад очсон юм.

МХАУТ-ын дарга С.Дэмбэрэл тус уулзалт дээр хэлсэн үгэндээ Хятадын бизнес эрхлэгчидтэй өргөн хүрээнд идэвхитэй хамтран ажиллаж буй тухай болон ӨМӨЗО, Шанхай, Жилиний худалдаа, аж вйлдвэрийн танхим зэрэг орон нутгийн бизнесийн бүтцүүдтэй хэлхээ холбоогоо өргөжүүлж буй тухай, мөн нийгмийн хариуцлагатай бизнесийг хөгжүүлэх шаардлагатай байгаа тухай өгүүлэв. Тэрбээр хоёр орны худалдаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа жилээс жилд өргөжин тэлж, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, мал аж ахуй зэрэг шинэ салбаруудыг хамран хөгжиж буй боловч худалдааны салбарт багагүй саад бэрхшээл оршсоор байгааг анхааруулсан байна. Түүний үзэж байгаагаар хоёр орны засгийн газар асуудлыг хамтран судалж, худалдааны нөхцлийг улам таатай болгох шаардлагатай байгаа ажээ. Хятад, Монголын эдийн засаг харилцан бие биеэ нөхөх ихээхэн боломжтой тул бид хамтын ажиллагаагаа идэвхижүүлэхийг үнэхээр сонирхдог бөгөөд Монголоос Хятад руу гарах экспортод оногдуулах татвар, тарифын бус саад тотгорыг эрс бууруулан чөлөөт худалдааны таатай орчин бүрдүүлэх нэн чухал байна. Мөн түүнчлэн бизнесийн мэдээллийн солилцоо хангалтгүй, хаа хаанаа мэдээлэл ихээхэн дутагдаж байгаа явдал бид бүхний хамгийн том асуудал бөгөөд энэ байдлыг өөрчлөх үүднээс МХАУТ, Хятадын олон улсын худалдааг дэмжих зөвлөл хамтран вэбсайт нээхээр ажиллаж байгаа ажээ. Энэхүү вэбсайтаас хоёр орны компаниуд хамтран ажиллах боломж бололцоо, хууль дүрэм, журмуудын тухай хамгийн шинэ сэргэг мэдээлийг эх хэл дээрээ олж авч байх болно гэжээ.

Хятадын олон улсын худалдааг дэмжих зөвлөлийн орлогч дарга Жан Вэй Хятад,

Монголын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хэтийн төлөвийн талаар ярихдаа, хоёр орон газар тариалан, уул уурхай, эрдэс баялгийн чиглэлээр хамтын ажиллагаагаа өргөжүүлэх болно хэмээн мэдэгдэв.<sup>12</sup>

Хятад орны эдийн засгийн түргэн хөгжил, техник, технологийн салбарт гарч буй ахиц дэвшил монголын бизнесменүүдэд таатай боломж бүрдүүлж байгааг бизнес уулзалтын үеэр Монголын зарим компаний удирдлага илэрхийлж байлаа. Тухайлбал, “Сэргэн мандал” группын ерөнхийлөгч Б.Төмөрчулуун, БНХАУ-ын бизнес эрхлэгчдээс Герман, Японтой хамтарсан вйлдвэрт бүтээсэн дулаан дамжуулах хуванцар хоолойн вйлдвэрийн тоног төхөөрөмж худалдан авах гэрээнд гарын үсэг зурсандаа сэтгэл хангалуун байгаагаа мэдэгдэв. Хятад улс технологийн хувьд тэргүүний гэгддэг Япон, Германтай зарим талаар ойртож, тэдний ялгаа нь багасч байна. Иймд хөгжингүй орнуудын бүтээгдэхүүнийг авах гэж заавал тухайн орон уруу явах шаардлагагүй боллоо. Хятадад вйлдвэрлэсэн хамтарсан вйлдвэрийнхнийг эндээс сонгон авч болж байна. Би эндээс анх удаа авч байна. Манайх өмнө нь дандаа Испани, Австрали, Германы технологийг авдаг байв. Тэгэхэд тээврийн зардал өндөр байсан. Одоо ойрхон болчихлоо хэмээн Б.Төмөрчулуун олзуурхан ярьсан байна.<sup>13</sup>

Хятад-Монголын бизнес форумын үеэр хоёр орны компаниуд нийтдээ 100 сая ам долларын өртөг бүхий хамтын ажиллагааны 5 гэрээнд гарын үсэг зуржээ.<sup>14</sup> Энэхүү 5 гэрээний хамгийн том нь Хятадын барилга, хөдөө аж ахуйн техник импорт экспортын компани Монголын нэгэн компанид нөөц усаар ажиллах цахилгаан станцын тоног төхөөрөмж нийлүүлэх 82 сая ам долларын өртөг бүхий гэрээ байлаа.<sup>15</sup>

БНХАУ-д албан ёсны айлчлал хийх үеэр Монгол Улсын Ерөнхий сайд М.Энхболд БНХАУ-аас Монгол Улсыг хавсран суугаа Дипломат төлөөлөгчийн газрууд, БНХАУ болон гадаадын хэвлэл мэдээллийнхэнд зориулж Бээжин дэх Монгол Улсын ЭСЯ-

<sup>12</sup> Chinese, Mongolian firms sign agreements worth 100-mln-U.S. dollars. China Daily, November 23, 2006

<sup>13</sup> <http://www.oloo.mn>. 2006-11-28, “Монголын мэдээ” сонин, 2006 он, №233 /2009/

<sup>14</sup> Neighbours seal US\$100m in deals. China Daily November 24, 2006

<sup>15</sup> “蒙古消息报” сонин (Монголын мэдээ, хятад хэлээр), 2006.11.28. №48 (3909)

нд 2006 оны 11-р сарын 23-ны өдөр брифинг хийв. Уг брифинг-д гадаадын элчин сайд, түр хамаарагч, дипломат ажилтнууд, БНХАУ болон гадаадын хэвлэл мэдээллийн төлөөлөгчид нийт 80 гаруй хүн оролцжээ.

Монгол Улсын Ерөнхий сайдын айлчлалыг тохиолдуулан Бээжин дэх Монгол Улсын ЭСЯ санаачилж БНХАУ-ын China Daily сонинд Монгол Улсын тухай тусгай хавсралтыг тус сонины 11-р сарын 23-ны өдрийн дугаарт хэвлүүлэв. Уг хавсралтад Монгол Улсын Ерөнхий сайд М.Энхболдын илгээлт, Элчин сайд Г.Батсүхийн ярилцлага, Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын нөхцөл, эдийн засгийн чөлөөт бүсүүд, үйлдвэрлэлийн парк, хөрөнгө оруулах төслүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл орсон байна. Мөн БНХАУ-ын Глобал Таймс сонинд Монгол Улсын талаар дэлгэрэнгүй мэдээлэл хэвлэгджээ. Мөн Монгол Улсын Засгийн газрын Хэвлэл, мэдээллийн албанаас мэдээлснээс үзвэл Ерөнхий сайд М.Энхболд БНХАУ-ын Төв телевиз CCTV-9-д ярилцлага өгчээ.

Ерөнхий сайд М.Энхболдын албан ёсны айлчлалын хоёрдахь хэсэг Хятадын хөдөө орон нутгийн хөгжлийн өнөөгийн байдал, түүх дурсгалын газруудтай үзэж танилцахад чиглэсэн байлаа. Ерөнхий сайдын зочилсон эхний газар бол Синьзян-Уйгурын өөртөө засах орон (СУӨЗО) юм. СУӨЗО нь их хэмжээний газрын тос, байгалийн хий олборлодог, манайтай хил залгаа оршдог, өргөн уудам нутагтай, уйгур, казах, монгол зэрэг үндэстний цөөнх зонхилон суудаг зэрэг олон онцлогтой газар нутаг юм. БНХАУ баруун бүс нутгаа хөгжүүлэх стратегийн томоохон зорилт тавин амжилттай хэрэгжүүлж буй бөгөөд СУӨЗО-ны хөгжлийг түргэтгэх замаар Төв Ази, Оросын Алтайн хязгаар, цаашдаа Европ, Азийн орнуудтай харилцаагаа өргөжүүлэх бодлого явуулж байна. Манай орны хувьд бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалаа хэрэгжүүлэх, баруун бүсийн холын аймгуудын эрэлт хэрэгцээг хямд, найдвартай бараа, бүтээгдэхүүнээр хангах, гадаад худалдаа, эдийн засаг, аялал жуулчлалыг хөгжүүлэхэд СУӨЗО чухал үүрэг гүйцэтгэх боломжтой. Гэхдээ ӨМӨЗО-той харьцуулахад Монгол Улс тус ӨЗО-той худалдаа, эдийн засгийн талаар харилцах талаар нэлээд хоцрогдонгүй

байгаа. Ийм ч учраас орон нутаг хоорондын шууд харилцаа, хамтын ажиллагааг улам хөгжүүлэх, хил худалдааг боловсронгуй болгох хоёр талын сонирхол нийлж байсан тул манай ерөнхий сайдын айлчлалын үеэр зочлох газруудын тоонд СУӨЗО-г оруулсан нь тохиолдлын чанартай байгаагүй гэдэг нь тодорхой байлаа.

Монгол Улсын Засгийн газрын тэргүүн М.Энхболд СУӨЗО-ны төв Үрэмч хотод хүрэлцэн ирэхэд СУӨЗО-ны Ардын Засгийн газрын дэд дарга Ху Вэй, СУӨЗО-ны Намын хорооны орлогч нарийн бичгийн дарга Сю Гуану болон албаны бусад хүн угтав. Ерөнхий сайд М. Энхболд тэргүүтэй төлөөлөгчид тус ӨЗО-ны удирдлагуудтай орон нутгийн харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх тодорхой асуудлууд, тухайлбал эрчим хүч, дэд бүтэц, боловсрол зэрэг салбаруудад хамтран ажиллах талаар санал солилцов. Хоёр талын хооронд худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны байнгын зөвлөлдөх ажлын хэсэг байгуулах саналыг монголын талаас тавив. Мөн хилийн боомтын дэд бүтцийг сайжруулах талаар хамтран ажиллах, хилээр зорчиж буй Монголын иргэдэд хөнгөн шуурхай үйлчилгээ үзүүлэх, хууль бус татвар хураамж авахгүй байх тухай асуудлыг хөндөж ярилцсан байна. Иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах үүднээс Үрэмч хотод Монгол Улсын Ерөнхий консулын газар байгуулах сонирхолтой байгаагаа мөн илэрхийлжээ. СУӨЗО-ны АЗГ-ын Тэргүүлэгч Исмаил Таливальди харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар санал нэгтэй байгаагаа илэрхийлэхийн хамт манай талаас дэвшүүлсэн хоёр талын хамтын ажиллагааг зохицуулан чиглүүлэх механизм бий болгох саналыг онцлон дэмжиж байна хэмээн мэдэгдэв.

Ерөнхий сайд М.Энхболд дагалдан яваа хүмүүсийнхээ хамт Үрэмч хот дахь нөхөн сэргээгдэх эрчим хүчний тоног төхөрөмжийн компаниудаар зочилж, ажил байдал, шинжлэх ухаан-технологийн сүүлийн үеийн ололт амжилттай нь үзэж танилцав. СУӨЗО-ны Зиньфэн компани нь салхины эрчим хүчний тоног төхөрөмж үйлдвэрлэх, худалдаалах, энэ төрлийн тоног төхөрөмжийг импортлох, ашиглалтыг нь зохион байгуулах, салхины эрчим хүчний станц байгуулах, ажиллуулах талаар техникийн зөвлөлгөө, үйлчилгээ

үзүүлэх зэрэг чиглэлүүдээр үйл ажиллагаа явуулдаг аж.

Харин Шинэ эрчим хүчний компани нь нарны эрчим хүчийг ашиглах тоног төхөөрөмж, өндөр хүчин чадалтай хяналтын бичил төхөөрөмж, зөөврийн цахилгаан станц, нефть, хий дамжуулах хоолойн хамгаалалтын систем, хиймэл дагуулын холбооны цахилгаан үүсгүүр, нарны эрчим хүчээр ажилладаг ахуйн цахилгаан үүсгүүр, гудамжны гэрэлтүүлэг, бохир ус цэвэрлэгч систем, зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэлээрээ алдартай ажээ.<sup>16</sup>

СУӨЗО-д зочилсны дараа 11-р сарын 26-ны өдөр Монгол Улсын Ерөнхий сайд М.Энхболд Шэньси мужид айлчлалаа үргэлжлүүлэхээр хүрэлцэн ирэхэд мужийн удирдлагууд угтсан байна. Шэньси муж нь Хятадын төв хэсэгт Шар мөрөн, Хөх мөрний хоорондох хөндийд оршдог. Ашигт малтмалын нөөцөөр улсдаа дээгүүр ордог. 90 гаруй төрлийн ашигт малтмалын орд илэрснээс нүүрс, төмөр, хөнгөн цагаан, хар тугалга, цайр, алт, фосфор, нефть, бал чулуу зэрэг 30 шахам төрлийн ашигт малтмал олборлолтоор Хятадаа эхний аравт ордог.

Шэньси мужийн төв Сиань хотноо Ерөнхий сайд М. Энхболд орон нутгийн эдийн засаг, аж үйлдвэрийн хөгжлийн бүсэд зочилжээ. Мөн энэ үеэр Шэньси мужийн ZTE корпорацийн дэд ерөнхийлөгч Пан Шэнци Ерөнхий сайд М. Энхболдод бараалхаж, өөрийн компанийн үйл ажиллагааны талаар танилцуулав.

Дараа нь Монгол Улсын Засгийн газрын тэргүүн М.Энхболд “Кан Шифу” хүнсний компанид зочилж, дэлхийд алдартай Цинши хааны бунхант цогцолборыг үзэж сонирхлоо. Цинши хаан бол Хятад орныг анх удаа нэгтгэсэн төдийгүй, Хятад орныг дэлхийд алдаршуулсан Их Цагаан хэрмийг байгуулсан, хятадын дүрс үсгийг төгөлдөржүүлэн хөгжүүлэхэд оруулсан хувь нэмэр, гүйцэтгэсэн үүргээрээ тус улсын түүхэнд алдар суу нь мөнхөрчээ. Энэ хааны үлдээсэн бас нэгэн өв бол Цин Ши хааны хойд насны бунхант ордон юм. Хятадын түүхийн ном сударт уг Цин Ши хааны орд харшийг дуурайлган урлаж, бас олон зэрэг зиндааны ноёд түшмэл, шадар бараа бологсдын хөшөө баримлыг цутган байрлуулж, үнэт эрдэнэс,

эд хогшлыг хувиран хийж дүүргэсэн бунхан байдаг тухай тэмдэглэн үлдээсэн байсныг үе үеийн эрдэмтэд уншиж мэдэн тасралтгүй эрж хайсаар байжээ. 1974 онд нэгэн тариачин өвгөн газар хагалж байгаад гэнэт цөмрөн доош унаснаар энэ бунханыг олж илрүүлсэн түүхтэй. Бунхны нийт урт 230 метр, өргөн нь 62 метр, гүн нь 65 метр юм. XX зууны археологийн гайхамшигт нээлтүүдийн нэг болсон эл газар доорхи ордон нь бүгд гурван хэсэг том бунхнаас бүрдсэн агаад хоорондоо 3–5 км зайтай толгодын дор оршдог. Гол бунханд 6000 гаруй явган ба морин цэргийн 180 см гаруй өндөр хүрэл, шавар хөшөөнүүд жагсаан байрлуулсан нь Цин Ши хааны торгон цэргүүд юм. Тэд инээсэн, уурссан, догшин амарлингуй, бодлогоширсон янз бүрийн байдалтай, сахалтай, сахалгүй, хөгшин залуу гэх мэт дахин давтагдашгүй өнгө төрхтэйгээр бүтээгджээ. Монгол Улсын Ерөнхий сайд Шэньси мужийн түүхийн музей, Тан гүрний үеийн 1300 гаруй жилийн өмнө баригдсан түүхийн дурсгал болох Зэрлэг галууны цамхагийг үзэж сонирхов.<sup>17</sup>

Шэньси мужийн захирагч Юань Чуньцин 2006 оны 11-р сарын 26-ны орой Ерөнхий сайд М.Энхболдод бараалхаж, хоёр тал харилцаа, хамтын ажиллагаа, ялангуяа аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа харилцан илэрхийлсэн байна.

Монгол Улсын Ерөнхий сайд М.Энхболд БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Вэнь Зябаогийн урилгаар 2006 оны 11-р сарын 22-27-нд БНХАУ-д хийсэн анхны албан ёсны айлчлал нь хоёр орны хооронд уламжлал болсон дээд, өндөр хэмжээний яриа хэлэлцээний үргэлжлэл бөгөөд хоёр орны хооронд тогтоосон сайн хөршийн, харилцан итгэсэн, түншлэлийн харилцааг бататган хөгжүүлэх, эдийн засгийн агуулгаар баяжуулах, Монгол Улсын ерөнхийлөгчийн 2005 онд БНХАУ-д хийсэн төрийн айлчлалын үеэр хоёр орны төрийн тэргүүн нарын хүрсэн тохиролцоог ажил хэрэг болгох талаар тодорхой үр дүнд хүрсэн, орон нутгийн харилцаа, хамтын ажиллагаанд томхон түлхэц үзүүлсэн улс төр, эдийн засгийн чухал ач холбогдол бүхий айлчлал боллоо.<sup>18</sup>

<sup>16</sup> “Өнөөдөр” сонин, 2006.11.25

<sup>17</sup> Ерөнхий сайд М.Энхболдын БНХАУ-д хийж буй албан ёсны айлчлал. 2006.11.26 <http://www.origo.mn>

<sup>18</sup> “ГАДААД ХАРИЛЦАА” Монгол Улсын ГХЯ-ны мэдээллийн товхимол, 2007 оны №2(178), х-21